



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/НЗ5

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.5, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Дүрэм батлах тухай” 200 дугаар тогтоолын 2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас 2021 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.44, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.4.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” төлөвлөгөөний 88 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 оны үйл ажиллагааны зардалд 5,070,000 (таван сая далан мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 5,070,000 (таван сая далан мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100925

D:My Doc. Zahiramj. Zasag darga